

МОНГОЛБАНКНЫ ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

№16/4

Улаанбаатар хот

Монголбанкны Захирлуудын зөвлөл (33) нь 2016 оны 08 дугаар сарын 18-ны өдөр хуралдсан бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдан явуулав.

2016 оны 08 дугаар сарын 18-ны өдөр 33 нь Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, мөнгөний бодлогын төлөвийг өөрчлөх хэд хэдэн хувилбар, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцсон бодлогын альтернатив хувилбаруудыг танилцуулав.

Америкийн Нэгдсэн Улсын эдийн засгийн өсөлт 2016-2017 онуудад тогтворжихоор байгаа бол Хятадын эдийн засгийн өсөлт бүтцийн шинэчлэлийн бодлоготой холбоотойгоор аажим саарахаар байна. Хятадын үйлчилгээний салбарын өсөлт, Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих бодлого болон мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлсэн зэрэг нь өсөлтийг дэмжих хэдий ч аж үйлдвэрийн салбарт эерэг дүр зураг ажиглагдахгүй байна. ОХУ-ын эдийн засгийн уналт саарч, тээвэр, үйлчилгээний салбарууд нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөг үзүүлж байна. Евро бүсийн хувьд дотоод эрэлт нэмэгдэж, хөдөлмөрийн захын төлөв сайжирч байгаа боловч Их Британи Европын холбооноос гарахтай холбоотойгоор 2017 онд бүсийн өсөлт саарах төсөөлөлтэй байна. Ийнхүү худалдааны түнш орнуудын эдийн засгийн өсөлт саарахаар байгаа нь манай улсын гадаад эрэлтийг бууруулж, дотоод эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхээргүй байна. Экспортын гол нэрийн барааны үнэ сүүлийн саруудад өсч эхэлсэн. Хятадын нүүрсний олборлолт буурч дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэхээр байгаа нь импортын нүүрсний хэрэглээг өсгөхөөр байна. Мөн BREXIT-тэй холбоотойгоор ирэх онд зэс, нүүрс, алтны үнэ алгуур өсч, худалдааны нөхцөл өмнөх төсөөллөөс сайжрах хүлээлттэй байна.

Эдийн засгийн өсөлт саарч, бизнесийн салбарын идэвхжил муудаж байна. Уул уурхайн бус салбарууд 5-6 улирлын турш агшиж, эдийн засгийн өсөлт 2 дугаар улиралд 0.1 хувьд хүрлээ. Эрэлт талаас засгийн газрын хэрэглээ, хөрөнгө оруулалт, гадаад худалдаа эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн бол өрхийн хэрэглээ буурсан нь сөрөг нөлөө үзүүлэв. Нийлүүлэлт талаас уул уурхай, ХАА, тээвэр, мэдээлэл, холбооны салбар өсөлтөд эерэгээр нөлөөлсөн бол бүтээгдэхүүний цэвэр татвар, барилга, боловсруулах салбар сөрөг нөлөө үзүүллээ. Эдийн засгийн өсөлт 2016 онд үргэлжлэн саарч, Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын нөлөөгөөр 2017 онд бага зэрэг нэмэгдэх төлөвтэй байна. Инфляцийн суурь төсөөллөөр 2017 оны 2 дугаар улирал хүртэл инфляци өнөөгийн түвшнээс бага байхаар байна.

Хөдөлмөрийн захын төлөв сайнгүй байна. Ажилгүйдлийн түвшин 2 дугаар улиралд 10.4 хувьд хүрч, ажиллах хүчний оролцооны түвшин буурч, хөдөлмөр шингээдэг салбаруудад агшилт үргэлжилж байгаа нь хөдөлмөрийн зах зээлд хүндрэл үүсгэж байна.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс алдагдалтай хэвээр, ирэх онуудад бондын эргэн төлөлтүүд хийгдэж, том дүнгээр хөрөнгө гадагшлахаар байгаа нь гадаад валютын нөөцөд дарамт үзүүлэхээр байна. Түүнчлэн, ханш огцом хөөрөгдөж, төгрөгт байршиж буй активын өгөөж буурч, хадгаламжийн долларжилт нэмэгдэх эрсдэлтэй байна. Ханшийн огцом хэлбэлзлийг намжаах, тогтворжуулах үүднээс Төв банкны зүгээс шийдвэртэй арга хэмжээг авах шаардлага тулгараад байна.

Энэхүү хурлаар инфляци, төгрөгийн ханш, өсөлт зэрэг эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн суурь болон альтернатив төсөөлөл, МБГ-аас гаргаж буй бодлогын саналыг танилцуулсан. Энэ нь 33-ийн гишүүдэд бодлогын нөлөө, үр дүнг харьцуулан дүгнэлт хийх боломж олгох юм.

МБГ-ын зүгээс 2016 оны эцэст инфляцийг зорилтот 7%-ийн түвшинд байлгах, ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулах, цаашлаад макро эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдлыг дунд хугацаанд хангах үүднээс Бодлогын хүүг 4.5 нэгж хувиар өсгөх, уламжлалт бус мөнгөний тэлэх бодлогыг үе шаттай хумих, 4 долоо хоногтой төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны хугацааг уртасгаж, хүүг бодлогын хүүн дээр нэмэх 2 нэгж хувиар тогтоох, заавал байлгах нөөц (ЗБН)-ийн урамшууллын хувийг хүүний коридорын доод хязгаарын 50 хувьтай тэнцэхээр, хүүний коридорыг тэгш бус хэмтэй тус тус тогтоох саналыг хурлаар танилцуулсан.

Танилцуулгын дараа 33-ийн гишүүд бодлогын саналыг шүүмжлэх болон дэмжих дараах байр суурийг илэрхийлэв.

Бодлогын саналыг шүүмжилж буй гишүүдийн зүгээс төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын хүүг өсгөж болох хэдий ч эдийн засгийн идэвхжил суларсан, мөнгө, зээлийн үзүүлэлтүүдийн өсөлт саарсан одоогийн нөхцөлд бодлогын хүүг огцом өсгөх нь бодит секторт ирэх дарамтыг улам нэмэгдүүлнэ. Нөгөө талаас бодлогын хүү өссөнөөр банкуудын эх үүсвэрийн зардал нэмэгдэж, цаашлаад хадгаламжийн хүү, зээлийн хүү өсөх нөхцөл бүрдэнэ. Зөвхөн төгрөгийн өгөөжийг өсгөх зорилгоор бодлогын хүүг нэмэгдүүлэх нь зээлийн хүү нэмэгдэх, зээлийн тасалдал үүсэх, улмаар банкуудын санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлд хүргэж болзошгүй тул бодлогын саналыг эргэн харахыг сануулав. Бодлогын хүүг огцом нэмэгдүүлэх тохиолдолд бодит секторт үзүүлэх нөлөөг харгалзан үзэж богино хугацаанд хэрэгжүүлэх нь зүйтэй гэдэг зөвлөмжийг мөн өгөв. Түүнчлэн, бодлогын хүүг цаашид удаан хугацаанд өндөр түвшинд хадгалах нь хямралыг улам даамжруулна гэсэн болгоомжлолыг илэрхийлэв.

Харин дэмжиж буй гишүүдийн зүгээс эдийн засагт үүсээд буй асуудлуудыг ач холбогдлоор нь эрэмбэлэх, нэн тэргүүнд зах зээлийн тогтворгүй байдал үүсэхээс сэргийлэх, төгрөгийн үнэ цэнийг яаралтай өсгөх чухал гэдгийг онцолсон. Үүнд ханшийн огцом хэлбэлзэл нь эдийн засгийн, улмаар нийгмийн тогтворгүй байдалд хүргэж болзошгүй ноцтой асуудал тул Монголбанкны зүгээс шийдвэртэй арга хэмжээ авах нь зөв гэдэг байр суурийг илэрхийлэв. Төгрөгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх хамгийн хүчтэй зэвсэг бол бодлогын хүүгээ өсгөх явдал юм. Эдийн засгийн идэвхжил агшсан, ажилгүйдэл 11 хувьд хүрсэн өнөө үед мөнгөний бодлогыг хатууруулах нь эдийн засгийг улам агшаах хэдий ч зах зээлийг богино хугацаанд тогтворжуулах зайлшгүй шаардлагатай байгааг илэрхийлэв. Валютын зах тогтворгүй байгаа энэ үед харьцангуй урт хугацаанд төгрөгийн нөөцийг өндөр өгөөжтэй байршуулах хэрэгсэл гаргах, зээлийн хүүн дээр ирэх дарамтыг бууруулахын тулд Заавал байлгах нөөцийн урамшууллын хувийг нэмэгдүүлэх хүртэл арга хэмжээг авч болох талаар гишүүд санал хэлэв.

Ийнхүү 33-ийн гишүүд мөнгөний бодлогын саналыг тал бүрээс нь авч үзэн, өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсний эцэст инфляци бага түвшинд хадгалагдаж, урсгал тэнцлийн алдагдал буурч, валютын орох болон гарах урсгалд нааштай хандлага ажиглагдаж байгаа хэдий ч төгрөгийн ам.доллартай харьцах ханш огцом суларсан энэ үед макро эдийн засгийн суурийг бэхжүүлэх, төгрөгийн ханшийн огцом сулрал гүнзгийрэхээс сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад бодлогын хүүг өсгөх нь бодлогын зайлшгүй сонголт болж байгаад санал нэгдлээ. Гэхдээ энэхүү бодлогын шийдвэр нь богино хугацаанд зах зээлд нөлөөллөө үзүүлэх тул эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг эхлэхээс өмнө дараагийн бодлогын хурлуудаар эргэн харах шаардлагатайг ихэнх гишүүд анхааруулж байв.

Бодлогын хүүг 4.5 нэгж хувиар өсгөх болон 4 долоо хоногтой ТБҮЦ-ны хугацааг уртасгаж 12 долоо хоног болгох, хүүг бодлогын хүүн дээр нэмэх 2 нэгж хувиар тогтоох, ЗБН-ийн урамшууллын хувийг хүүний коридорын доод хязгаарын 50 хувьтай тэнцэхээр тогтоох, хүүний коридорыг тэгш бус хэмтэй тогтоох /банк хоорондын захын хүүний коридорын дээд хязгаарыг бодлогын хүүн дээр нэмэх 3 нэгж хувь, доод хязгаарыг-бодлогын хүүгэс хасах 1 нэгж хувь/ талаар санал хураахад 33-ийн олонх гишүүд дэмжив.

Тус арга хэмжээг авсанаар төгрөгийн ханшийг хамгаалах, төгрөгийн активын өгөөжийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад эерэгээр нөлөөлнө гэдэгт зөвлөлийн гишүүд санал нэгдсэнээр 33-ийн хурал өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны 33-ийн 2016 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 15 хувьд хүргэх, 4 долоо хоногтой ТБҮЦ-ны хугацааг уртасгаж 12 долоо хоног болгох, хүүг бодлогын хүүн дээр нэмэх 2 нэгж хувиар тогтоох, ЗБН-ийн урамшууллын хувийг хүүний коридорын доод хязгаарын 50 хувьтай тэнцэхээр, хүүний коридорыг тэгш бус хэмтэйгээр тус тус тогтоох шийдвэр гаргав.